



**ДОРНОГОВЬ АЙМАГ  
МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 11/62

Төхөм

**Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага  
худалдаа зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоол, Мандах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээ, зохион байгуулах хэлбэр, хугацааг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ШИЖИР

4426010134

Сумын Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 26 ны өдрийн  
№ 167 дугаар захирамжийн хавсралт

**ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА,  
ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛБЭР, ХУГАЦАА**

№	Газрын байршил	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Дуудлага худалдааны анхны үнэ /төг/	Дэнчингийн хэмжээ /төг/	Зохион байгуулах	
							Хэлбэр	огноо
1	Шарга дэл	4865811	2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	1502	901,200	90,120	Цахим	2026.05.07
2	Номгон ертөөнөөс баруун урагшаа	4944291	2127: Терминал (ачиж, буулгах талбай)	100000	60,000,000	6,000,000	Цахим	2026.05.07
3	Нарангийн хоолой	4944295	3412: Ус хангамжийн барилга, байгууламж	60516	36,309,600	3,630,960	Цахим	2026.05.07
4	Нарангийн хоолой	4944296	3412: Ус хангамжийн барилга, байгууламж	2669	1,601,400	160,140	Цахим	2026.05.07
5	Нарангийн хоолой	4944297	3412: Ус хангамжийн барилга, байгууламж	521413	312,847,800	31,284,780	Цахим	2026.05.07
6	Борхошуун төмөр замын хойд талд	4944301	2127: Терминал (ачиж, буулгах талбай)	992115	595,269,000	59,526,900	Цахим	2026.05.07
7	Онгоны гудамж	4949798	2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	400	240,000	24,000	Цахим	2026.05.07
<b>Дүн</b>				<b>1678615</b>	<b>1,007,169,000</b>	<b>100,716,900</b>		